



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/31/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 80

танай _____ ны № _____ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.УРАНЧИМЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат сан, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020132

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,997,068.74	73,367,526.43
33	АВЛАГА	7,500,000.00	3,319,000.00
335	Бусад авлага	7,500,000.00	3,319,000.00
3351	Байгууллагаас авах авлага	7,500,000.00	3,319,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	72,497,068.74	70,048,526.43
351	Түүхий эд материал	1,062,400.00	626,400.00
35130	Эм боох материал	1,062,400.00	626,400.00
354	Хангамжийн материал	71,434,668.74	69,422,126.43
35410	Бичиг хэргийн материал	402,650.00	350,400.00
35420	Аж ахуйн материал	64,448,771.74	64,789,618.43
35430	Сэлбэг хэрэгсэл	-	20,000.00
35450	Барилгын засварын материал	134,000.00	110,000.00
35460	Хүнсний материал	4,888,947.00	2,880,645.00
35470	Бусад хангамжийн материал	1,560,300.00	1,271,463.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	798,146,778.90	790,110,680.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	798,146,778.90	790,110,680.00
392	Биет хөрөнгө	787,345,095.10	779,609,104.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	708,123,281.52	708,123,281.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,247,539.08)	(43,121,970.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,444,850.00	53,603,750.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,983,397.38)	(8,592,349.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,195,176.43	93,577,736.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,881,717.39)	(25,700,784.33)
39217	Ном	1,694,441.00	1,719,441.00
393	Биет бус хөрөнгө	10,801,683.80	10,501,575.20
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,051,901.00	10,051,901.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(600,217.20)	(900,325.80)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	878,143,847.64	863,478,206.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	878,143,847.64	863,478,206.43
51	Засгийн газрын хувь оролцоо	878,143,847.64	863,478,206.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	44,274,716.00	44,274,716.00
512	Хуримтлагдсан үр дүн	694,066,428.13	679,400,786.92
51210	Өмнөх үеийн үр дүн	694,066,428.13	694,066,428.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	(14,665,641.21)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,802,703.51	139,802,703.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	878,143,847.64	863,478,206.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	934,677,440.50	364,860,102.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	572,046,540.50	18,872,960.50
120	Нийтлэг татварын бус орлого	561,446,540.50	8,072,960.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	561,446,540.50	8,072,960.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	561,446,540.50	8,072,960.50
122	Тусламжийн орлого	10,600,000.00	10,800,000.00

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

122001	Хандив тусламж /дотоод/	10,600,000.00	10,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	362,630,900.00	345,987,142.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320,989,500.00	301,683,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,989,500.00	301,683,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,641,400.00	44,103,442.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,641,400.00	44,103,442.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	377,462,209.90	379,525,743.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,462,209.90	379,525,743.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,997,412.24	355,052,369.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,668,909.16	225,037,583.30
210101	Үндсэн цалин	129,979,132.95	139,972,592.39
210102	Нэмэгдэл	61,665,839.00	66,870,053.61
210104	Урамшуулал	18,023,937.21	18,194,937.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,884,342.78	30,041,127.65
210201	Тэтгэврийн даатгал	18,063,442.78	20,996,443.71
210202	Тэтгэмжийн даатгал	2,205,200.00	2,304,594.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,764,200.00	1,715,016.12
210204	Ажилгүйдлийн даатгал	441,000.00	435,687.69
210205	Эрүүл мэндийн даатгал	4,410,500.00	4,589,385.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,653,718.00	43,107,442.00
210301	Гэрэл, цахилгаан	3,846,453.00	2,586,784.00
210302	Түлш, халаалт	36,807,265.00	39,778,255.00
210303	Цэвэр, бохир ус	-	742,403.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,043,322.84	13,463,293.31
210401	Бичиг хэрэг	1,062,540.00	977,450.00
210402	Тээвэр, шатахуун	739,580.00	1,002,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	477,200.00	439,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,873,200.00	3,936,324.70
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		1,238,000.00
210408	Бараа материал акталсны зардал	882,802.84	5,670,378.61
2105	Нормативт зардал	18,411,165.00	10,986,064.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,621,950.00	1,212,400.00
210502	Хоол, хүнс	16,789,215.00	9,773,664.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,033,540.00	810,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	106,040.00	104,100.00
210604	Урсгал засвар	927,500.00	706,200.00
2107	Томилолт, зочны зардал	368,000.00	124,000.00
210702	Дотоод албан томилолт	368,000.00	124,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,373,914.46	31,482,559.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,000.00	20,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	325,000.00	860,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,990,914.46	30,602,559.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,464,797.66	24,473,374.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	470,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	470,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	45,994,797.66	23,973,374.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,994,797.66	23,973,374.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	557,215,230.60	(14,665,641.21)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	556,306,465.68	(14,665,641.21)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр
/

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,274,716.00	139,802,703.51	694,066,428.13		878,143,847.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,274,716.00	139,802,703.51	694,066,428.13	-	878,143,847.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-		-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,274,716.00	139,802,703.51	694,066,428.13	-	878,143,847.64
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	44,274,716.00	139,802,703.51	694,066,428.13	-	878,143,847.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,274,716.00	139,802,703.51	694,066,428.13	-	878,143,847.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(14,665,641.21)		(14,665,641.21)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,274,716.00	139,802,703.51	679,400,786.92	-	863,478,206.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	372,630,900.00	356,787,142.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,000,000.00	10,800,000.00
122	Тусламжийн орлого	10,000,000.00	10,800,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	10,000,000.00	10,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	362,630,900.00	345,987,142.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320,989,500.00	301,683,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,989,500.00	301,683,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,641,400.00	44,103,442.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,641,400.00	44,103,442.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	349,895,290.00	356,787,142.00

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,895,290.00	356,787,142.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303,400,492.34	332,313,767.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,921,981.56	225,037,583.30
210101	Үндсэн цалин	130,232,205.35	139,972,592.29
210102	Нэмэгдэл	61,665,839.00	66,870,054.23
210104	Урамшуулал	18,023,937.21	18,194,936.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,884,342.78	30,041,127.65
210201	Тэтгэврийн даатгал	18,063,442.78	21,120,372.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,205,200.00	2,381,431.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,764,200.00	1,695,016.82
210204	Ажилгүйдлийн даатгал	441,000.00	438,197.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,410,500.00	4,406,108.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,653,718.00	43,107,442.00
210301	Гэрэл, цахилгаан	3,846,453.00	2,586,784.00
210302	Түлш, халаалт	36,807,265.00	39,778,255.00
210303	Цэвэр, бохир ус	-	742,403.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,311,480.00	5,592,653.00
210401	Бичиг хэрэг	494,800.00	558,900.00
210402	Тээвэр, шатахуун	739,580.00	840,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	477,200.00	334,000.00
210404	Ном, хэвлэл	-	65,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,289,000.00	1,692,913.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,310,900.00	2,101,300.00
2105	Нормативт зардал	6,596,380.00	8,416,262.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	60,900.00
210502	Хоол, хүнс	5,936,380.00	7,765,362.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	590,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,187,500.00	15,193,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	7,469,300.00
210602	Тавилга	1,387,500.00	6,728,400.00
210604	Урсгал засвар	800,000.00	996,000.00
2107	Томилолт, зочны зардал	368,000.00	124,000.00
210702	Дотоод албан томилолт	368,000.00	124,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	865,500.00	569,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	757,500.00	569,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,611,590.00	4,231,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,892,150.00	1,052,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,719,440.00	3,179,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,494,797.66	24,473,374.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	45,994,797.66	23,973,374.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,994,797.66	23,973,374.05
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	25,497,400.00	14,566,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,497,400.00	14,566,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,497,400.00	14,566,500.00
222001	Тоног төхөөрөмж	1,800,000.00	7,469,300.00
223001	Бусад хөрөнгө	23,697,400.00	7,097,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(25,497,400.00)	(14,566,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(2,761,790.00)	(14,566,500.00)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/
төгрөгөөр
/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	343236506.48	362650900.00	319400992.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	306638506.48	362650900.00	302512992.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	306138506.48	362150900.00	302012992.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	181284474.48	219724100.00	209921981.56
210101	Үндсэн цалин	0.00	138639500.00	135727500.00	130232205.35
210102	Нэмэгдэл	0.00	23583400.00	57707800.00	61665839.00
210104	Урамшуулал	0.00	19061574.48	26288800.00	18023937.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	22670100.00	28420800.00	26884342.78
210201	Тэтгэврийн даатгал	0.00	15415700.00	19599900.00	18063442.78
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1813600.00	2205200.00	2205200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	1450900.00	1764200.00	1764200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	362700.00	441000.00	441000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	3627200.00	4410500.00	4410500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	34367724.00	40861400.00	40653718.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	4554384.00	5700000.00	3846453.00
210302	Түлш, халаалт	0.00	29813340.00	32474600.00	36807265.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	2686800.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2202228.00	14783400.00	5311480.00
210401	Бичиг хэрэг	0.00	126400.00	500000.00	494800.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	928928.00	740000.00	739580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	74,500.00	483,700.00	477,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	2,281,000.00	2,289,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,044,400.00	10,710,900.00	1,310,900.00
2105	Нормативт зардал	-	47,086,315.00	38,070,000.00	6,596,380.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	90,000.00	63,300.00	60,000.00
210502	Хоол, хүнс	-	46,391,315.00	37,400,300.00	5,936,380.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	605,000.00	606,400.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	7,239,800.00	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	-	800,000.00	800,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	107,900.00	431,800.00	368,000.00
210702	Дотоод албан томилолт	-	107,900.00	431,800.00	368,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	204,100.00	2,347,500.00	865,500.00

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	204,100.00	889,500.00	757,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	108,000.00	108,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,975,865.00	16,711,900.00	10,611,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,491,900.00	6,092,300.00	1,892,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,483,965.00	10,619,600.00	8,719,440.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	500,000.00	500,000.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00	500,000.00	500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	36,598,000.00	-	16,888,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	36,598,000.00	-	16,888,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	17,648,000.00	-	1,800,000.00
223001	Бусад хөрөнгө	-	18,950,000.00	-	15,088,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	343,363,900.00	362,630,900.00	362,630,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	292,188,700.00	320,989,500.00	320,989,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	292,188,700.00	320,989,500.00	320,989,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	35,175,200.00	41,641,400.00	41,641,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	35,175,200.00	41,641,400.00	41,641,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	9,996,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,387,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,387,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,387,500.00
210602	Тавилга	-	1,387,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,609,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	8,609,400.00
223001	Бусад хөрөнгө	-	8,609,400.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, өглөг үүсгэхгүй байхгүй, анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэг нь “Хүүхдийн хөгжлийг дэмжих, амжилттай суралцахад “Шинэ багш” “Шинэ Ирээдүй” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаандаа 9 зорилтын хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Шинэ багш”, “Шинэ Ирээдүй” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд багш, удирдах ажилтан, эцэг эх, орон нутгийн удирдлагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах
2. Гэнэтийн буюу давтагдашгүй хүчин зүйлийн үед бэлэн байдлын төлөвлөгөөтэй ажиллах
3. Аймгийн болон байгууллагын цахим хичээл, цахим даалгаврын санг бүтээлчээр ашиглах
4. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан цахим технологийг нэвтрүүлэн сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
5. Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих, боловсролд тэгш хамруулах, сургуульд бэлтгэхэд анхаарч багш, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах
6. Боловсролын газрын мэргэжил арга зүйн баг, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, багш хөгжлийг дэмжих
7. Багш, ажилтанд стрессээс сэргийлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажиллах, төрийн албан хаагч, багшийн ёс зүйг баримтлан, байгууллагын соёл, байгууллагын стандартыг мөрдөж ажиллах
8. Хичээл сургалтын үйл ажиллагааг улирлын байдлаас үл хамааран гадна орчинд зохион байгуулах боломжийг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах
9. Сургуульд орох 5 настай хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулах тал дээр анхаарч сургалтыг 100 хувь хүргэх гэсэн зорилттой ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 378370.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3783.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2648.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Өмнөх оны үр дүн буураагүй тул тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/Мян.төг /		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	7500.0	3319.0	4181.0
Бараа материал	72497.06	70048.5	2448.5
Үндсэн хөрөнгө	845859.6	868426.1	-22566.4
Нийт хөрөнгө	878143.8	863478.2	14665.6

Өглөг	0		0
Хуримтлагдсан үр дүн	694066.4	819203.5	-125137.06
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	878143.8	863478.2	14665.6

Авлага: Тайлант оны эхэнд 7500.0 мянган төгрөгийн авлагатай байснаас 70048.5 мянган төгрөгийг барагдуулж тайлант оны 4181.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 72497.06 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 70048.5 мянган төгрөг болж өмнөх оноос 2448.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 22322.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 22322.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан материал байхгүй байна.

Нийт 24770.6 мянган төгрөгийн бараа материал хасагдсанаас 19254.6 мянган төгрөг зарцуулж, аж ахуйн материалтай холбоотой бусад 5516.05 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 845859.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 868426.1 мянган төгрөг болж өмнөх оноос 22566.4 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 14493.5, дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 8072.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд шилжүүлсэн болон акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр: Өглөгийн дансанд оны эхний үлдэгдэл эцсийн үлдэгдэлгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулалтад 425601.7 мянган төгрөгийн төсөв батлуулахаар төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулалтад 356787.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 312683.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 44103.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 312683.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 44103.4 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 332813.8 мянган төгрөгийг зарцуулж 23973.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас ариутгал халдвар хамгааллын хэрэгсэлд зориулж 0.2 сая төгрөгийн санхүүжилт олгож хог хаягдал зайлуулах зардал зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Нэмэлт данс болон үндсэн данснаас хэмнэгдсэн хэмнэлтээс 14493.5 мянган төгрөгийг хөрөнгө бэлдсэн
- Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 590,000 төгрөгийн ажлын хувцас худалдан авсан зэрэг Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар “Шилэн дансны тухай”, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд нийт 147 мэдээлэл оруулахаас хугацаа хоцроосон мэдээлэл 12, хугацаанд нь оруулсан 135 мэдээг мэдээлсэн боловч цахим хуудасны хөтлөлтийн чанар байдлыг үзвэл төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 1 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/09 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17335.2 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 681.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож, 16653.7 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох 3 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа гараагүй

4.2 Төлбөрийн акт

Сангийн яамны и-хуулганы нийт цалингийн зардлыг санхүүгийн тайлангийн цалингийн зардалтай тулган үзэхэд 681,473.1 төгрөгийн зөрүү үүссэн нь зориулалт бус зарцуулалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Нэмэлт данс болон үндсэн данснаас хэмнэгдсэн хэмнэлтээс 14493.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлдсэн нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тотоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Бага үнэтэй түргэн элэгдлийн зардлаас 1,570,200 төгрөгөөр угаалгын машин, зурагт, принтер худалдан авч хөрөнгө бэлтгэсэн нь Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 590,000 төгрөгийн ажлын хувцас худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тотоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу нэмэгдсэн өртгийн албан татварын баримтгүй 4 гүйлгээ байгаа байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасан заалтыг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой

3.1 Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээлэл нийт 147 мэдээлэл оруулахаас 12 мэдээлэл хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бүрэгхангай сумын хүүхдийн цэцэрлэг	6	17335.2	0	0	1	681.5	3	16653.7	2	0
Нийт дүн		6	17335.2			1	681.5	3	16653.7	2	0